



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	12
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.5.3 Нэмэлт төсөв:.....	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2. Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ЖАВХЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.ЧИМЭД-ОЧИР ТАНАА**

2025-02-25 № СЭА-2025/102/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайланг онд Боловсролын яамнаас зарласан "Ерөнхий боловсролын сургуульд цахим анги байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж"-ийг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендэрт шалгарсан Консалтинг ХХК-иас 84,997,0 мянган төгрөгийн, Юнившн ХХК-иас 17,073.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авч хөрөнгийн орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гөл асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа еерчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	189,740,927.72	250,561,657.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	119,618,145.58	160,888,793.95
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	119,618,145.58	160,888,793.95
3121	Төгрөг	119,618,145.58	160,888,793.95
31211	Төрийн сангийн харилцах	119,618,145.58	160,888,793.95
33	АВЛАГА		270,185.75
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		270,185.75
35	БАРАА МАТЕРИАЛ	70,122,782.14	89,402,678.22
354	Хангамжийн материал	70,122,782.14	89,402,678.22
3541	Бичиг хэргийн материал	11,199,602.14	12,239,430.22
3542	Аж ахуйн материал	33,925,730.00	46,708,048.00
3546	Хүнсний материал	3,732,450.00	1,748,000.00
3547	Бусад хангамжийн материал	21,265,000.00	28,707,200.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,320,069,323.90	1,511,564,966.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,320,069,323.90	1,511,564,966.59
392	Биет хөрөнгө	1,314,737,157.38	1,506,336,966.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,310,437,665.00	1,310,437,665.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-140,181,735.29	-171,628,312.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,562,499.68	-14,562,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	167,584,664.10	387,610,019.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-84,931,740.55	-129,662,248.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,171,597.64	161,424,918.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,791,874.14	-64,405,280.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,865,400.00	7,865,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-959,195.40	-1,151,034.48
39217	Ном	8,542,375.70	5,845,840.64
393	Биет бус хөрөнгө	5,332,166.52	5,228,000.00
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,145,833.48	-1,250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,228,000.00	5,228,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,509,810,251.62	1,762,126,624.51
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		77,229,825.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		77,229,825.00
413	Өглөг		77,229,825.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,752,056.00
4136	Бусад өглөг		75,477,769.00
41361	Байгууллагад төлөх өглөг		75,477,769.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,509,810,251.62	1,684,896,799.51
51	Засгийн газрын хувь оролцоо	1,509,810,251.62	1,684,896,799.51

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	462,309,496.49	462,309,496.49
51101	Өмч: - төрийн	457,081,496.49	457,081,496.49
512	Хуримтлагдсан үр дүн	347,403,610.83	522,490,158.72
5121	Өмнөх үеийн үр дүн	347,403,610.83	347,403,610.83
5122	Тайлант үеийн үр дүн		175,086,547.89
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	700,097,144.30	700,097,144.30
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,509,810,251.62	1,762,126,624.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөгөөр/
			Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,518,338,010.43	1,832,175,013.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	212,484,265.64	196,417,773.70
120	Нийтлэг татварын бус орлого	212,484,265.64	196,417,773.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,309,668.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	181,486,566.90	185,535,170.72
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	27,688,030.74	10,847,602.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,853,744.79	1,635,757,240.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,081,094,000.00	1,408,417,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,081,094,000.00	1,408,417,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,759,744.79	217,339,340.03
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,759,744.79	217,339,340.03
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,230,485,945.83	1,654,391,930.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,230,485,945.83	1,654,391,930.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,188,602,345.83	1,606,695,160.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,380,000.40	1,055,051,704.62
210101	Үндсэн цалин	540,437,723.59	755,479,212.01
210102	Нэмэгдэл	174,145,855.16	242,730,992.61
210104	Урамшуулал	30,796,421.65	56,841,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,500,336.32	126,381,287.63
210201	Тэтгэврийн даатгал	65,460,494.94	86,629,894.08
210202	Тэтгэмжийн даатгал	7,624,183.09	9,692,613.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,958,546.54	4,631,484.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,403,386.08	4,631,484.17
210205	Эрүүл мэндийн даатгал	14,053,725.67	20,795,811.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186,172,176.86	214,126,396.03
210301	Гэрэл, цахилгаан	12,209,913.00	12,176,254.52
210302	Түлш, халаалт	170,242,263.86	196,098,141.51

210303	Цэвэр, бохир ус	3,720,000.00	5,852,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,027,733.12
210408	Бараа материал акталсны зардал		4,027,733.12
2105	Нормативт зардал	45,073,505.00	48,544,590.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,560.00	
210502	Хоол, хүнс	44,863,945.00	48,544,590.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,901,820.00	12,223,102.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,661,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,240,420.00	12,223,102.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,574,507.25	146,340,346.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,713,412.50	40,847,423.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,080,500.00	2,740,930.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,597,594.75	102,751,992.97
210904	Найдваргүй авлагын алдагдал	183,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,883,600.00	47,696,770.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,883,600.00	47,696,770.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,146,100.00	37,656,170.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,737,500.00	10,040,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	287,852,064.60	177,783,082.95
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,696,535.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		2,696,535.06
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-2,696,535.06
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	287,852,064.60	175,086,547.89

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,309,163,412.79	1,635,792,240.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,309,668.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,309,668.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,309,668.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,853,744.79	1,635,757,240.03
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,081,094,000.00	1,408,417,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,081,094,000.00	1,408,417,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,759,744.79	217,339,340.03
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,759,744.79	217,339,340.03

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,161,981,098.58	1,558,590,360.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,161,981,098.58	1,558,590,360.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,119,945,148.58	1,510,768,840.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,847,989.40	1,055,321,890.37
210101	Үндсэн цалин	554,986,964.78	690,867,767.13
210102	Нэмэгдэл	164,704,768.86	304,508,051.44
210104	Урамшуулал	32,156,255.76	59,946,071.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,032,347.32	126,381,287.63
210201	Тэтгэврийн даатгал	61,264,478.45	85,894,593.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,880,668.12	10,131,022.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,460,374.50	5,063,684.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,310,160.33	5,056,301.40
210205	Эрүүл мэндийн даатгал	13,116,665.92	20,235,685.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186,172,176.86	212,374,340.03
210301	Гэрэл, цахилгаан	11,767,013.00	12,176,254.52
210302	Түлш, халаалт	170,685,163.86	196,098,141.51
210303	Цэвэр, бохир ус	3,720,000.00	4,099,944.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	47,822,145.00	46,435,390.00
210502	Хоол, хүнс	47,822,145.00	46,435,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,643,600.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	10,643,600.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,351,820.00	12,063,102.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,661,400.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,690,420.00	12,063,102.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,075,070.00	53,192,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,284,002.00	43,822,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,791,068.00	9,370,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,035,950.00	47,821,520.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,035,950.00	47,821,520.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,298,450.00	37,780,920.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,737,500.00	10,040,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	147,182,314.21	77,201,879.37
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	47,144,400.00	35,931,231.00
	Дотоод эх үүсвэрээр	47,144,400.00	35,931,231.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,144,400.00	35,931,231.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-47,144,400.00	-35,931,231.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	100,037,914.21	41,270,648.37

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		119,618,145.58
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		160,888,793.95

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,309,496.49	700,097,144.30	347,403,610.83	1,509,810,251.62
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			175,086,547.89	175,086,547.89
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,309,496.49	700,097,144.30	522,490,158.72	1,684,896,799.51

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,756,244,500.00	1,594,521,591.66	161,722,908.34	90.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,756,244,500.00	1,558,590,360.66	197,654,139.34	88.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,707,885,500.00	1,510,768,840.66	197,116,659.34	88.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,171,311,700.00	1,055,321,890.37	115,989,809.63	90.1
210101	Үндсэн цалин	751,448,700.00	690,867,767.13	60,580,932.87	91.9
210102	Нэмэгдэл	392,628,400.00	304,508,051.44	88,120,348.56	77.6
210104	Урамшуулал	27,234,600.00	59,946,071.80	-32,711,471.80	220.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,414,100.00	126,381,287.63	20,032,812.37	86.3
210201	Тэтгэврийн даатгал	99,561,500.00	85,894,593.32	13,666,906.68	86.3
210202	Тэтгэмжийн даатгал	11,713,100.00	10,131,022.58	1,582,077.42	86.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,856,600.00	5,063,684.35	792,915.65	86.5
210204	Ажилгүйдлийн даатгал	5,856,600.00	5,056,301.40	800,298.60	86.3
210205	Эрүүл мэндийн даатгал	23,426,300.00	20,235,685.98	3,190,614.02	86.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,448,900.00	212,374,340.03	74,559.97	100.0
210301	Гэрэл, цахилгаан	12,072,000.00	12,176,254.52	-104,254.52	100.9
210302	Түлш, халаалт	196,098,700.00	196,098,141.51	558.49	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,278,200.00	4,099,944.00	178,256.00	95.8
2105	Нормативт зардал	60,051,400.00	46,435,390.00	13,616,010.00	77.3
210502	Хоол, хүнс	60,051,400.00	46,435,390.00	13,616,010.00	77.3

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,393,900.00	12,063,102.63	10,330,797.37	53.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,393,900.00	12,063,102.63	10,330,797.37	53.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,265,500.00	53,192,830.00	37,072,670.00	58.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,895,000.00	43,822,330.00	37,072,670.00	54.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,370,500.00	9,370,500.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,359,000.00	47,821,520.00	537,480.00	98.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,359,000.00	47,821,520.00	537,480.00	98.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,318,400.00	37,780,920.00	537,480.00	98.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,040,600.00	10,040,600.00		100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		35,931,231.00	-35,931,231.00	
	Дотоод эх үүсвэрээр ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		35,931,231.00	-35,931,231.00	
1	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,746,244,500.00	1,635,792,240.03	110,452,259.97	93.7
131	Улсын төсвөөс санхүүжих	1,528,795,600.00	1,418,417,900.00	110,377,700.00	92.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,528,795,600.00	1,408,417,900.00	120,377,700.00	92.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00	-10,000,000.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	217,448,900.00	217,339,340.03	109,559.97	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	217,448,900.00	217,339,340.03	109,559.97	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		35,000.00	-35,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		119,618,145.58	119,618,145.58	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		160,888,793.95	160,888,793.95	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль нь “Суралцагчийн эзэмших чадамжийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулан сурагч бүрийг уншиж ойлгон, ойлгосноо илэрхийлэх чадварт сургах, таван соёлыг хэвшүүлэн дадал болгох ” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдын хандлагад анхаарч, хөгжил хамгаалал, оролцоог дэмжин хүүхэд бүртэйгээ тулж ажилладаг болох;
- Хүүхэд бүрийн сурлагын ахиц, амжилтыг ахиулах, бие даан суралцах арга барилд сургах;
- Төгсөх ангийн сурагчдын хичээл сонголтод уян хатан хандаж, карьер төлөвлөлтийг илүү сайн дэмжих;

- Цахим орчинд ажиллах, нөхцөлийг сайжруулж, цахим платформ дээр ажиллах.Багш бүр суралцахууд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах;

3.2.Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл,үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор”Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл,чанар,үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн

зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жавхланта сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 252,316.4 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	119,618.1	160,888.8	41,270.6
Авлага	-	270.2	270.2
Бараа материал	70,122.8	89,402.7	19,279.9
Үндсэн хөрөнгө	1,320,069.3	1,511,565.0	191,495.6
Нийт хөрөнгө	1,509,810.3	1,762,126.6	252,316.4
Өглөг	-	77,229.8	77,229.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,509,810.3	1,684,896.8	175,086.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,509,810.3	1,762,126.6	252,316.4

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 160,888.8 мянган төгрөг болж 41,270.6 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 -д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансанд нягтлан бодогч төлбөр тооцоог хянаагүйгээс цалинтай холбоотой 270.2 мянган төгрөгийн авлага шинээр үүссэнээс
- Бараа материал дансны үлдэгдэл 89,402.7 мянган төгрөг болж 19,279.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 123,737.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БЕГ-аас 4,366.7 мянган төгрөгийн түрээсийн ном,сурах бичиг, Дэлхийн Зөн ОУБ-аас 5,480.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, өж ахуйн материал, эцэг эхчүүдээс 1,000.0 мянган төгрөгийн сандал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, цаашид ашиглах боломжгүй 4,027.7 мянган төгрөгийн ном, сурах бичгийг сургуулийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/19 дүгээр тушаалын дагуу акталж данс бүртгэлээс хассан, үйл ажиллагаанд 111,277.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,894,247.8 мянган төгрөг болж 279,605.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 35,931.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендерт шалгарсан Максим Консалтинг ХХК-иас цахим ангийн 84,997.0 мянган төгрөгийн үнэтэй, Юнивишн ХХК-иас 17,073.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Боловсролын газраас 26,931.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн зөн ОУБ болон бусад байгууллага иргэдээс 23,634.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар цахим ангийн 114,969.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ширээ сандлыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, элэгдлээ бүрэн нөхсөн 17,362.0 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолын дагуу акталж данс бүртгэлээс хассан зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 382,659.4 мянган төгрөг бөгөөд 1,511,588.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.
- Өр төлбөр данс мянган төгрөгөөр 77,229.8 нэмэгдсэн нь цахим ангийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авсан, 1,752.0 мянган төгрөгийн тогтмол зардлын өр шинээр үүссэнээс шалтгаалсан байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,217,644.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 233,890.4 мянган төгрөг, нийт 1,451,534.6

мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 75,521.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг 5,685.1 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 13,807.8 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 15,000.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,441.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 156,224.7 мянган төгрөгөөр нийт 292,681.0 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 30,010.6 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 858.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 1,189,722.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,538,795.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 217,448.9 мянган төгрөгийн нийт **1,756,244.5** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 483,828.2 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 7,166.7 мянган төгрөгөөр;
- Урсгал засварын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 22,393.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 34,719.6 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 13,429.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж
- Хичээл үйлдвэрлэлийн зардлыг 15.6 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,756,244.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,594,521.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,203,769.0 мянган төгрөг буюу 84.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 161,722.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							/мянган төгрөг/	
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь	
		1	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,699.2	1,699.2	-	100.0	
1	71802 Ерөнхий боловсрол	2	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,408.5	2,408.5	-	100.0	
		3	80233-Хүүхэд хамгаалал	2,557.2	1,074.5	1,482.7	42.0	
		4	80312- Сургалт семинар	1,769.0	1,605.0	164.0	90.7	
		5	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,657.5	2,657.5	-	100.0	
		6	81801- Үдийн цай хөтөлбөр	38,318.4	37,780.9	537.5	98.6	
		7	81806-Дотуур байр	220,152.1	187,312.7	32,839.4	85.1	
		8	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	29,794.2	29,794.2	-	100.0	

	9	81823- Боловсролын багшийн сургалт	6,963.4	2,780.0	4,183.4	39.9
	10	81827-бичиг үсгийн боловсрол	9,251.8	7,572.9	1,678.9	81.9
	11	81834- Боловсролын стандарт сургалт	1,166,288.5	1,046,810.9	119,477.6	89.8
	12	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	43,639.0	42,909.2	729.8	98.3
	13	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	70.0	-	70.0	-
	14	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр	3,226.8	2,741.7	485.1	85.0
	15	83603- Дээд шатны төсвөөс	10,000.0	10,000.0	-	100.0
	16	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	217,448.9	217,374.3	74.6	100.0
	Нийт		1,756,244.5	1,594,521.6	161,722.9	90.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байрны хоол	60,051.4	60,051.4	НТШ
2	Үдийн цай	38,318.4	38,318.4	НТШ
	Нийт дүн	98,369.8	98,369.8	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ - ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Баянжаргалан хайрхан” ХХК-тай гэрээг байгуулж худалдан авалтыг гүйцэтгэжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн *Цаашид Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль гэх* 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,230,485.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,304.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жавхлант сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 911 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон худалдан авах ажиллагаатай холбоотой 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлжээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2		2		100.0
Нийт дүн	2		2		100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 7,681.7 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 7,681.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 270.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 1 албан шаардлага, хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1.Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 270.2 мянган төгрөгийн цалингийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үнэ төлбөргүй орлого	1	7,681.7			1	7,681.7	1	7,681.7				
Дүн	1	7,681.7			1	7,681.7	1	7,681.7				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	270.2			1	270.2						
Дүн	1	270.2			1	270.2						



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 91/А.1850385

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 270.2 мянган төгрөгийн цалингийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: “Хууль тогтоомж,зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төлбөр, тооцоог хянаагүйн улмаас авлага үүсгэсэн зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жавхлант сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Чимэд-Очир, нягтлан бодогч Б.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТОР

Б.НАРАНЧИМЭГ

432504213

АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймаг Жавхланта сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/102/НА-СТА-ТШЗ	
1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит	
1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	41/.../А 1850385 СЭА-2025/102/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2025.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/ 270,200.00

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч үгтг	Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 270.2 мянган төгрөгийн цалингийн авлага үүсгэсэн байна.		
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11: "Хууль тогтоомж,зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль	
		Заалт	6.4.8	
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаал		
	Заалт	4.2.1.9, 4.2.1.11		

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Бараа материалын тайлан		2024 он	
2	Харилцахын баримт		2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Жавхланта ЕБС	Захирал	Н.Чимэдочир	91062200
				Нягтлан бодогч	Б.Эрдэнэцэцэг	99253361

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	11/05	-	
2	Аудитын менежер	11/25	-	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
---	--------------	----------	-------	------------

1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	<i>Ч/Э</i>	<i>Ч/Э</i>
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2025.02.24	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Жавхлант ЕБС	
		Ажилтны	Овог нэр	Б.Эрдэнэцэцэг
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Пийк Ом Аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		